

ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН АЛБАН ШААРДЛАГЫН БИЕЛЭЛТ

2025.06.09

Аудитын өгсөн үүрэг даалгавар	Хэрэгжилтийн биелэлт	Биелэлтийн хувь
2025 ОНЫ 360/АО370220-АРА-2025/02/НА-СТА-ЗГТС АЛБАН ШААРДЛАГА		
1.Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж өр авлага төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.	2024 оны тайлант онд 3 -аас дээш жилийн насжилттай 3 аж ахуйн нэгж байгууллагын 5.6 сая төгрөгийн авлагатай тайлагнасан. 2025 онд авлагыг бууруулах ажлын хүрээнд: 1. Ар сүлдэн хонгор ХХК -ний 0.7 сая төгрөгийн шимтгэлийн авлагыг Сум дундын анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан. 2. Мөн 2.7 сая төгрөг шимгэлийн авлага үүсгэсэн Хас зэндмэнэ ХХК -ний захирал, эзэн холбогдогч нь олдохгүй байгаа тул эрэн сурвалжилуулахаар Архангай аймаг дахь сум дундын анхан шатны шүүхэд хүсэлт гарган, шийдвэрийг хүлээж байна. 3. Цөм сүргийн үржлийн төв /Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар/-ийн үүссэн авлагыг Засаг даргын тамгын газар болон Орон нутгийн өмчийн газартай хуримтлагдсан авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Үүний үр дүнд Ар сүлдэн хонгор ХХК-ны 0.7 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг 100 хувь барагдуулан ажиллалаа.	100.0%
2025 ОНЫ 361/АО370220-АРА-2025/02/НА-СТА-ЗГТС АЛБАН ШААРДЛАГА		
2.Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д “төсвийн төвлөрүүлэн захирагчжилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 3 дугаар сарын 05-ны өдрийн дотор өрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийлгэсэн тайланг жилий бүрийн 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх, 15 дугаар зүйлийн 15.4.1 д “Төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх, 16 дугаар зүйлийн 16.5.7-д байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах.	2025 оны 1-5 дугаар сарын Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, тайлангаа Sicos системээрээ мэдээлж тайлагнаж хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2, 15 дугаар зүйлийн 15.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.7 дахь заалтын дагуу 2025 оны хагас жилийн Нийгмийн даатгалын санхүүгийн тайлангаа хугацаандаа хүргүүлж тайлагнах хүлээгдэж буй гүйцэтгэлтэй байна.	100%

АРХАНГАЙ АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР